

ГАРЧИГ

ОРШИЛ	2
НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	9
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ.....	11
ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	20
ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	26
ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	32
ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	33
НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	35
ЕС. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	35
АРАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	36
АРВАН НЭГ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	38
АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	43
АРВАН ГУРАВ.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	45
АРВАН ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	46
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ЗАДАРГАА /2024 ОН/	48

*“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч
хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө*

ОРШИЛ

“Болд төмөр Ерөө гол” (БТЕГ)ХХК нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Төмрийн хүдрийг ил аргаар олборлох төсөл хэрэгжүүлж байна. Тус компани Монгол Улсын холбогдох хуулийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНҮ)-г төслийн бүхий л үе шатанд мэргэжлийн байгууллагаар дэс дараатай хийлгэж, түүний зөвлөмж, заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

“Болд төмөр Ерөө гол” ХХК нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хэрэгцээ шаардлагын тэнцвэрийг олох зарчмаар тогтвортой хөгжлийг дэмжих үүрэг хүлээсэн билээ. Байгаль орчны талаархи үйл ажиллагааг цаг үргэлж сайжруулж байхын тулд дараах үүрэг хүлээж, хэрэгжилтийг ханган ажилладаг. Үүнд:

- Байгаль орчны бохирдлоос сэргийлэх, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах зорилгоор байгаль орчинд учирах нөлөөллийг тодорхойлж, бодитоор үнэлж, бохирдлыг бууруулж, арилгах арга хэмжээ авах;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох дүрэм, журмыг сахин биелүүлэх;
- Ашигт малтмалын хайгуул хийх, барилга байгууламж барих, уурхайн олборлолт ба уурхайн хаалт зэрэг үйл ажиллагааны бүхий л үе шатанд байгаль орчны асуудлыг тусган хэрэгжүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх, ажилтнуудад экологийн боловсрол олгох зорилгоор сургалтыг тогтмол зохион байгуулах,
- Байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хянах, хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагааг тогтмол сайжруулах;
- Компанийн ажилтнууд, хувьцаа эзэмшигчид, нутгийн иргэдтэй байгаль орчны асуудлаар нээлттэй, шударга, эргэх холбоо бүхий ажил хэрэгч харилцааг буй болгох;
- Нутгийн ард иргэдийн уламжлал, соёлыг хүндэтгэж хамгаалах;

“БТЕГ” ХХК-ний “Төмрийн хүдрийг хуурай соронзон аргаар баяжуулах Баянгол төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 дугаар журмын дагуу боловсрууллаа.

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: MV-008888, MV-017607 тоос тусгай зөвшөөрлийн дугаартай “Баянгол төмрийн хүдрийн орд”-ыг ил аргаар ашиглах, хуурай баяжуулах үйлдвэрийн төсөл.


Төсөл хэрэгжүүлэгч: “Болдтөмөр ерөө гол” ХХК, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар 9019007019. Регистрийн дугаар 2855119, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Сэлбэ гудамж-20. Утас:11329360

Төслийн байршил: Улаанбаатар хотоос 380км, Ерөө сумын төвөөс урд зүгт 35 км, Дархан хотоос зүүн хойш 150 км, Сүхбаатар хотоос зүүн урагш 130 км, Улаанбаатар Сүхбаатар чиглэлийн засмал замаас 75км зайд байрлах ба хамгийн ойр төмөр замын станц болох Дулаанхаанаас 80 км-г оршино. Энэхүү тусгай зөвшөөрөл бүхий ашиглалтын талбай нь Монгол Улсын байр зүйн зургийн М-48-95 хавтгайд байрладаг.

Хүснэгт-1. Тусгай зөвшөөрлийн мэдээлэл .

Тусгай зөвшөөрөл №	Олгогдсон (Он сар өдөр)	Хугацаа (жил)	Д/д	Х	У
Газарзүйн солбицол М-48-83					
MV-008888 (1405.41 га)	2007-02-13	30	1	107°09'1.32"II	49°38'26.96"II
			2	107°00'1.31"II	49°38'26.96"II
			3	107°00'1.31"II	49°39'18.95"II
			4	107°09'1.32"II	49°39'18.97"II
MV-017607 (275.01 га)	2011-11-10	30	1	107°05'29"II	49°39'130"II
			2	107°09'100"II	49°39'130"II
			3	107°09'100"II	49°39'18.96"II
			4	107°05'29"II	49°39'18.96"II

Зураг-1. Төслийн байршилын тойм зураг.



**“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч
хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө**

Уурхайн жилийн хүчин чадал, ашиглах хугацаа: Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших MV-008888, MV-017607 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Баянголын төмрийн хүдрийн орд” нь В+С зэрэглэлээр 66,1 сая тонн металл агуулсан 151,2 сая тонн төмрийн хүдрийн нөөцтэй байсан ба 2008-2019 онд 37,9 сая тонн хүдрийг олборлож, хуурай соронзон аргаар баяжуулсан ба 2019-01-01 ний өдрийн байдлаар 50,2 сая тонн металл агуулсан 117,5 сая тонн хүдрийн нөөцтэй байна. “Болд төмөр ерөө гол” ХХК нь тус ордыг ашиглах MV-008888, MV-017607 дугаартай 2 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ба нийт талбай нь 1680,5 га болно. Ордын хүдэр бүхий талбай нь зүүн, баруун, төв гэсэн үндсэн 3 хэсэгт хуваагдаж 10 хүдрийн биет, 2 хүдэржилтийн бүс, хэд хэдэн жижиг линз хэлбэрийн биетүүдээс бүрдэнэ. 3 хүдрийн биетүүд нь өөр хоорондоо 1.5-7 км-ийн зайтай оршдог. Баруун уурхай 1964,6 мян.м3 буюу 8251,3 мянган тонн, зүүн уурхай 15111,8 мян.м3 буюу 60992,1 мянган тонн, Төв ил уурхай 504,2 мян.м3 буюу 2117,8 мянган тонн, нийт дүнгээрээ 17580,6 мян.м3 буюу 71361,2 мянган тонн хүдрийн үйлдвэрлэлийн нөөцтэй. 2019 онд Уул уурхайн зураг төслийн “Ляпись Лазурь эрдэнэ” ХХК-иар тодотгол ТЭЗҮ боловсруулж, батлуулжээ. ТЭЗҮ-д тусгаснаар зүүн ил уурхайд жилийн 5000 мянган тонн хүдэр олборлох хүчин чадлаар 12.2 жил, баруун уурхайд жилийн 1000 мянган тонн хүчин чадлаар 8.2 жил ажиллах юм. Төвийн уурхайн хувьд сүүлийн жилд олборлохоор төлөвлөжээ. Ил уурхайн хүрээ хязгаарт ашиглах үйлдвэрлэлийн нөөц 71362,2 мянган тонн, 149207,6 мян.м3 хөрс хуулалтын ажил хийж, нийтдээ 166788.21 мянган м3 уулын ажил гүйцэтгэнэ. Баянгол уурхайд байнгын болон түр ажлын байранд нийт 1071 хүн ажиллаж байна.

Ил уурхайн ашиглалтын систем: Баянголын төмрийн хүдрийн ил уурхайд хөрс хуулалт, болон хүдэр олборлолтын ажлыг өрөмдлөг тэсэлгээ, экскавацлалт, автотээвэр гадаад овоолго гэсэн ил уурхайн ашиглалтын системээр гүйцэтгэдэг. Ордын хүдэр бүхий талбай нь зүүн, баруун, төв гэсэн үндсэн 3 хэсэгт хуваагдаж 10 хүдрийн биет, 2 хүдэржилтийн бүс, хэд хэдэн жижиг линз хэлбэрийн биетүүдээс бүрдэнэ.

Дээрх үндсэн 3 хүдрийн биетүүд нь өөр хоорондоо 1.5-7 км-ийн зайтай оршдог. Үүнээс барууны 1, 2 зүүний 1, 2, 4, 4а төвийн 2, 3, 4 хүдрийн биетүүдэд хайгуулын ажлыг илүү нарийвчлалтай гүйцэтгэж нөөцийг нь үйлдвэрлэлийн зэргээр тогтоосон учир 3 хүдрийн биетийн нөөцийг авч байна.

Зүүн хүдрийн биет нь дотроо үндсэн 4 хүдрийн биетээс тогтдог. Энэ тооцоонд 1, 2-р хүдрийн биетүүдийн нөөцийг бүрэн ашиглахаар, 4-р хүдрийн биетийн бодитой В нөөцийг бүрэн, бодитой нөөцийг олборлоход зайлшгүй өртөх боломжтой С нөөцүүдийг тус тус олборлохоор тусгасан болно.

Баянголын төмрийн хүдрийн ил уурхайд хөрс хуулалт, болон хүдэр олборлолтын ажлыг өрөмдлөг тэсэлгээ, экскавацлалт, автотээвэр гадаад овоолго гэсэн ил уурхайн ашиглалтын системээр гүйцэтгэж ирсэн болно.

Тус ордын хүдрийг нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнд тодорхойлсон гүн хүртэл ил уурхайгаар хүдрийн биетийн уналын дагуу дээрээсээ доош гэсэн ерөнхий чиглэлтэй, хүдрийн биетийн суналын дагуу уулын ажлын ахилттайгаар гүйцэтгэнэ.

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

Экскаваторуудын техникийн үзүүлэлтүүд болон хүдэр, хөрсний чулуулгийн физик механикийн шинж чанаруудаас хамааруулан хөрс хуулалтын болон хүдэр олборлолтын ажлын доголын өндрийг 6-12 метр байхаар тооцоолсон болно.

Ил уурхайн ашиглалтын дараалал

Шимт хөрс хуулалт: Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.2-0.5 метрээс ихгүй зузаантайгаар сийрэгжилтийн ажлыг хийлгүйгээр шууд бульдозероор түрж, экскаватороор утган автосамосвалд ачин ил уурхайн үржил шимт хөрсний гадаад овоолгод байрлуулна. Шимт хөрс хуулалтын ажилд 4 м 3 -ын утгуурын багтаамжтай VOLVO-EC маркийн экскаватор, 41 тн даацтай TEREX-50 маркийн автосамосвал, Shantui маркийн бульдозерын хослолоор хуулна. Шимт хөрсийг уурхайн талбайн гадна зөөвөрлөж овоолно. Өрнөлтгүй болсон овоолго, уурхайн бүрэн ашиглагдсан газарт техникийн нөхөн сэргээлт хийсний дараа шимт хөрсөөр хучна. Ил уурхайн тэсэлгээний ажлыг туслан гүйцэтгэгч “Монтай-Эрдэнэ” ХХК-иар гүйцэтгүүлдэг. Үржил шимт хөрсний овоолгыг баруун ил уурхайн хөрсний гадаад овоолготой залгаа зүүн талд, зүүн ил уурхайн хөрсний гадаад овоолгын зүүн болон зүүн хойд талд 2.5 метрээс ихгүй өндөртэйгээр 550.0 мян.м3 эзэлхүүнтэй овоолго байгуулна.

Үндсэн хөрс хуулалтын ажил: Үндсэн хөрсний чулуулгийн хатуулаг нь VIII-X зэрэглэлд хамаарагдаж байгаа нь хөрсний чулуулгийг авахдаа урьдчилан ерөмдлөгтэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэлтийн ажлыг хийсний дараа хөрсний гадаад овоолгод шилжүүлэх болно. Хөрс хуулалтын ажлын догол нь 6-12 м өндөртэй байна. Хөрс хуулалтын ажилд 12-16 м3 утгуурын багтаамжтай WK-12, KOMATSU PC3000, CAT-385 маркийн экскаватор, 41-91 тн даацтай TEREX-50, TEREX-100 маркийн автосамосвалууд тус тус ажиллана.

Хүдэр олборлолт: Хөрсний доголтой нэгэн адил, суналын дагуу чиглэсэн уулын ажлын ахилттай. Ил уурхайн хүдэр олборлолтын догол нь 6 м өндөртэй байна. Хүдэр олборлолтод 4-5 м 3 утгуурын багтаамжтай урвуу утгуурт CAT-385C, VOLVO-EC маркийн гидравлик экскаватор, 41 тн даацтай TEREX-50 маркийн автосамосвалын хослолоор ажиллана. Ил уурхайн автосамосвалууд хөрс, хүдрийн тээвэрлэлтэд ажиллах хосолмол ажиллагаатай байна.

Уурхайн дотоод тээвэр: Баянголын ил уурхайд БНХАУ-ын хамтарсан TEREXфирмийн автосамосвалуудыг ашигладаг. Мөн 2018 оны 8-р сараас тус уурхайд ашиглаж эхэлсэн Япон улсад үйлдвэрлэсэн Комацу фирмийн PC-3000 маркийн автосамосвалуудыг хөрс хуулалтын ажилд хэрэглэнэ. Тээвэрлэлтийн дундаж зай баруун ил уурхайд 1.5-1.7 км, зүүн ил уурхайд 1.3-1.5 км байна. Автосамосвалын тэвшний эзлэхүүн 16-26 м3 байх шаардлагатай.

Овоолго: 2007 оноос хойш өнөөг хүртэл нийт 30.0 сая.м3 хөрс хуулалтын ажил хийсэн бөгөөд зүүн, баруун ил уурхайнуудын хөрсний гадаад овоолгууд нь уурхайтай залгаа ил уурхайн эцсийн хүрээний гадна талаас эхлэн баруун ил уурхайн хувьд зүүн урд болон хойд талд зүүн ил уурхайн хувьд хойд болон урд талдаа байрладаг. Эдгээр

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

овоолгуудыг үргэлжлүүлэн тэлж, дунджаар 40-60м өндөртэй хөрсний гадаад овоолгууд уурхайн эцсийн байдлаар үүснэ. Баруун, зүүн уурхайнуудын хөрсний овоолгуудад дунджаар 43-120 метр өндөртэй нийт 147.69 сая.м3 хөрсний чулуулгийг байршуулна.


Гадаад тээвэр: Төмрийн баяжмалыг автомашин болон төмөр замаар тээвэрлэн БНХАУ-д экспортлоно. Баянголын төмрийн хүдрийн ил уурхайгаас Хандгайт өртөө хүртэл маршрутаар нийт 15 км шороон замаар тээвэрлэнэ. Төмөр замын тээвэр: Хандгайт өртөөнөөс улсын урд хил хүртэл тээвэрлэх зай 1160 км төмөр замаар тээвэрлэнэ.

Төсөл хэрэгжилтийн явц: Батлагдсан нөөцийн дагуу Баруун, Зүүн гэсэн 2 ил уурхай, хуурай хүдэр баяжуулах 5-н үйлдвэр ажиллаж байна. Баянголын төмрийн хүдэр олборлох ил уурхай нь олон төрлийн холимог шинж чанартай бөгөөд одоогийн байдлаар өндөр агуулгатай төмрийн хүдрийг гарган авахын тулд одоогоор хуурай соронзон сеператорыг ашиглаж байна.

Төмрийн хүдрийг ангилан ялгах хэсэг нь дараах дамжлагуудаас бүрдэнэ.

- Хүдрийг буталж, боловсруулалтанд бэлдэх
- Соронзон аргаар ялган, ангилах
- Хаягдлыг хадгалах зэрэг болно.

Схем-1. Үйлдвэрийн өдөр тутмын үйл ажиллагааны технологийн дараалал.



Ил уурхайн ажиллах горим: Уурхайн ажиллах горимыг уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээнээс хамааруулан 3-р сарын 15-аас 12-р сарын 15-ны хооронд, хоногийн 12 цагийн үргэлжлэлтэй 2 ээлжээр ажиллахаар төсөлд тусгасан. Уурхайн жилд ажиллах хоногийг дараах байдлаар үзүүлбэл:

Жилийн нийт хоног 365 хоног

- Үндэсний баяр, ёслолын хоног 9 хоног
- Өвлийн улирлын сул зогсолт 90 хоног
- Засвар үйлчилгээ, бэлтгэл ажил 18 хоног
- Цаг агаарын нөхцөлийг тооцсон хоног 8 хоног
- Уурхайн жилд ажиллах хоног 240 хоног
- Хоногт ажиллах ээлжийн тоо 2 ээлж
- Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг тус тус байна.

Ашиглагдаж буй техник технологи:

Уулын үндсэн техник тоног төхөөрөмжүүд.

Дээрх ажлуудыг гүйцэтгэхэд дэлхийд ил уурхайн тоног төхөөрөмж үйлдвэрлэлээр тэргүүлэх фирмүүдийн техник тоног төхөөрөмжүүдийг сонгон авч байна. Үүнд:

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

Хүснэгт-2. Баянгол уурхайн хэмжээнд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Тоног төхөөрөмжийн нэр	Марк	Хүчин чадал	Тоо ширхэг	Үйлдвэрлэгдсэн улс
1	Экскаватор-CAT	3895CL	5.2м3	3	АНУ
2	Экскаватор-KOMATSU	PC 400	2.2м3	1	Япон
3	Экскаватор-KOBELCO	SK 330-7		1	Солонгос
4	Экскаватор-HYUNDAI	LC-500	3.2м3	1	Солонгос
5	Экскаватор-VOLVO	EC700CL	4м3	6	БНХАУ
6	Цахилгаан экскаватор-TZ	WK-12	12м3	2	БНХАУ
7	Цахилгаан экскаватор-KOMATSU	PC -3000	12м3	1	Япон
8	Бульдозер-SHANTUI	SDR-22	6м3	5	БНХАУ
9	Ачигч-LIUGONG	ZL-50C	2.5м3	1	БНХАУ
10	Ачигч- VOLVO	L350	6.2м3	7	БНХАУ
11	Өрмийн машин-ATLAS COPCO	ROC-460PC	98мм	2	БНХАУ
12	Өрмийн машин-ATLAS COPCO	ROC-L-830	200мм	2	БНХАУ
13	Өрмийн машин-ATLAS COPCO	CDM-30	178мм	2	БНХАУ
14	Өрмийн машин-ATLAS COPCO	KQG-150V	110мм	2	БНХАУ
15	Автосамосвал-TEREX	TRX-50	50тн	16	БНХАУ
16	Автосамосвал-TEREX	TRX-100	100тн	9	БНХАУ
17	Автосамосвал-KOMATSU	HD-785-792	100тн	8	Япон
Нийт				69	
18	Баяжуулах үйлдвэр /хуурай/		4,0-6,0 сая	5	

Баяжуулалтын технологи.

Баянголын төмрийн хүдрийн ордын төв биет, баруун биет болон зүүн биетийн 1, 2, 4-р хүдрийн биетийн хүдэр олборлох хэсгийн дэргэд нийтдээ хуурай соронзон аргаар баяжуулах 5 үйлдвэр ажиллаж байна. Ордын баруун хүдрийн биетээс жил бүр дунджаар 40-41.5%-ийн төмрийн агуулгатай 1.0 сая.тн хүдэр, зүүн биетээс 41-44.4%-ийн төмрийн агуулгатай 3.7 сая.тн анхдагч хүдэр, нийтдээ жил бүр 4.7 сая.тн хүдрийг хуурай соронзон аргаар баяжуулахаар төлөвлөсөн. Хуурай соронзон баяжуулах 5 үйлдвэрээс 1,2,3-р үйлдвэр тус бүр хос шугамтай ба шугам тус бүрийн жилийн хүчин чадал 500.0-650.0 мян.тн ба үйлдвэрүүдийн жилийн хүчин чадал нийтдээ 4700.0мян.тн байна.

Хүдэр жигдрүүлэлт: Баяжуулах процессод орж байгаа хүдрийн шинж чанар, хүдэр дэх ашигт болон хорт хольцын агуулгын өөрчлөлт нь үйлдвэрийн хүчин чадал, ажлын горим, баяжмалын чанар, бүтээгдэхүүний гарц, металл авалт зэрэгт нөлөөлдөг. Ийм учраас баяжуулах үйлдвэрийн технологийн процессыг хэвийн жигд явуулах зорилгоор хүдэр жигдрүүлэлтийн ажлыг хийдэг. Уурхайгаас ирэх хүдэр дэх төмрийн агуулга болон хорт хольцын агуулга ерөнхийдөө жигд учир уурхайгаас тээвэрлэн ирэх хүдэрт урьдчилсан хүдэр жигдрүүлэлтийн ажил хийгдэхгүй. Гэхдээ баяжуулах үйлдвэрийг жигд агуулгатай

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

хүдрээр тасралтгүй хангаж байх зорилгоор хүдэр буулгах талбай дээр хүдрийн жигдрүүлэлтийг хянаж ажиллана.

Хүдэр бутлалт: Анхдагч хүдрийн овоолгоос -600мм-ийн ширхэглэлтэй хүдрийг утгуурт ачигчаар дамжуулан анхдагч бутлуурын тэжээлийн бункерт өгнө. Хүдрийг -8мм хүртэл 4 шатны бутлалт, 2 шатны хяналтын шигшилттэй схемээр буталж ангилна. Анхдагч хүдрийг 2 шатны бутлуураар буталсны дараа чичиргээт шигшүүрээр 3 шатны бутлалттай схемийн хувьд -12мм, 12-35мм, +35мм-ийн ширхэглэлээр, 4 шатны бутлалтын схемийн хувьд -8мм, +8мм-ийн ширхэглэлээр шигшин ангилна. Схемүүдийн хувьд шигшүүрийн нэмэх ангилал буюу +8, +35мм-ийн ширхэглэлтэй хүдрийг 3-р шатны бутлуурт гүйцээн буталж битүү циклээр шигшүүрт дахин шигшинэ. 3 шатны бутлалттай схемийн хувьд -12мм болон 12-35мм-ийн ширхэглэлтэй хүдрийг тус тус-д нь баяжуулна. 4 шатны бутлалттай схемийн хувьд +8мм-ийн ангилалыг дахин 2 шатны бутлалт, 1 шатны хяналтын шигшилтээр 8мм хүртэл ширхэглэлтэй болтол бутлана.

Хүдэр баяжуулалт: Шигшилтээс гарах -8мм болон -12мм, 12-35мм-ийн ширхэглэлтэй хүдрийг тус тусад нь 36*120 DW ER маркийн хуурай соронзон сепаратороор баяжуулна. Анхан шатны соронзон баяжуулалтаас баяжмал болон хаягдал ялгарах ба баяжмалыг 1 шатны цэвэрлэгээний хуурай соронзон сепаратороор баяжуулна. Цэвэрлэгээний хуурай соронзон сепаратороос 58-58.3%-ийн төмрийн агуулгатай эцсийн баяжмал болон 31-32%-ийн төмрийн агуулгатай завсрын бүтээгдэхүүн ялгарна. Баяжуулах үйлдвэрээс эцсийн байдлаар 58-58.3%-ийн төмрийн агуулгатай бүхэллэг болон нунтаг баяжмал, 31-32%-ийн төмрийн агуулгатай завсрын бүтээгдэхүүн болон 12.2-12.4%- ийн төмрийн агуулгатай хаягдал бүтээгдэхүүнүүд гарна. Баяжуулах үйлдвэрийн сорьц авах шаардлагатай хяналтын 11 цэгээс 3 цаг тутам дээж авч төмрийн агуулгыг тодорхойлон хянаж ажиллана.

Баяжмалын овоолго: Баяжуулах үйлдвэрээс нарийн болон бүхэллэг ширхэглэлтэй төмрийн баяжмал болон завсрын бүтээгдэхүүнүүд тус тусдаа ялгагдана. Баяжмалын овоолгыг баяжуулах үйлдвэрийн баруун талд 30-40м зайд тусгай бэлдсэн талбайд байршуулна. Баяжмалыг овоолгоос утгуурт ачигчаар дамжуулан баяжмал тээвэрлэх машинд ачна. Баяжмалын овоолгоос хоногт нэг удаа хяналтын дээжлэлт хийлгэж итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн баяжмалын агуулгыг чанарын шаардлагад нийцүүлэн ажиллана.

Хаягдлын овоолго: Баяжуулах үйлдвэрээс -35мм-ийн ширхэглэлийн ангилалтай бүхэл, нунтаг гэсэн 2 фракцын хаягдал гарна. Хаягдалд агуулагдах төмрийн агуулга 12.2-12.4% байна. Хаягдлуудыг тус бүрд нь овоолго үүсгэн хадгалж уурхайн хэмжээнд уурхайн дотор болон гадна тээврийн замын арчилгаанд хучилт, баяжуулах үйлдвэрийн хаягдлын овоолгыг дарах зэргээр хэрэглэх ба үлдсэн хэсгийг овоолго хийж байршуулна. Баяжуулах үйлдвэрүүд нийтдээ жилд 4700.0мян.тн төмрийн хүдэр баяжуулан 12- 15%-ийн агуулгатай 884.0- 1202.2мян.тн /295.0-400.0мян.м3/ хуурай хаягдал гарна. Уурхайн төлөвлөлтөөр нийт 12 жилийн хугацаанд 55761.2мян.тн хүдэр олборлон баяжуулж 12635.5мян.м3 хуурай хаягдал ялгарна.

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Цахилгаан хангамж: “Болдтөмөр Ерөө гол” ХХК нь уурхайн төслийн хүрээнд Дарханы агаарын шугамаас Хандгайт хүртэлх агаарын шугамын бүтээн байгуулалтын гэрээг 2012 оны 05-р сард хийсэн. Дарханаас Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Хандгайтын даваа хүртэлх 103 км урт, 2 хэлхээт 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 50-70Мвт-ын дэд станц баригдаж байна. Төслийн 60-70% нь хийгдэж байгаа бөгөөд 2019 онд бүрэн ашиглалтад оруулна. Төсөл ашиглалтад орсноор Сэлэнгэ аймгийн бүх нутаг 2 талын цахилгааны эх үүсвэртэй болж байгаа давуу талтай. Дэд бүтцийн цахилгаан хангамжийн гол хэрэглэгчид нь уурхайн тосгон, авто бааз зуурмагийн цех, Хандгайт өртөө, төмөр замын ачилтын хэсэг, үйлдвэрийн усан хангамж зэрэг болно.

Уурхайн хотхон: Уурхайн тосгоны бүрэлдэхүүнд уурхайн захиргааны байр, ажилчдын орон сууц, аж ахуйн зориулалттай барилга байгууламжууд, хоолны газар, халуун усны газар, эмнэлэг завсарын газар, агуулахууд, ХААН банкны салбар, 8 нэрийн хүнс барааны дэлгүүр харуулын байр зэрэг барилга байгууламж багтана.

Зураг-2. Уурхайн хотхон



Цэвэрлэх байгууламж: Ахуйн бохир усыг цэвэршүүлж хоногийн 24 цагт 2 ээлжээр тасралтгүй ажиллаж байна. Тухайн цэвэрлэх байгууламж нь 200 м³ хүртэл усыг 98% хүртэл цэвэршүүлэх хүчин чадалтай юм. Баянгол уурхайд ажиллаж буй энэхүү байгууламж нь 1 цагт 8-10м³ ахуйн бохир усыг цэвэршүүлэн гаргаж байна. Зуны улиралд цэвэрлэгдэж гарсан усыг тоосжилтыг /зам, хуурай баяжуулах/ дарахаар ашиглаж байна. Өвлийн улиралд усалгаанд хэрэглэгдэхгүй учир цэвэршүүлсэн усыг таригдсан моддын цэнэг усалгаанд ашиглаж байна.

Шилэн кабель: УБТЗ-ын Ерөө өртөөнөөс “Баянгол” уурхай чиглэлд нийт 12 шөрмөс бүхий GYTE53 маркийн 105 км шилэн кабель татсан. Эдгээрээс ХЗХ, интернэт, дотоод сүлжээ, ДНЦ яриа, АТС, видео хурал, телехяналтын систем зэрэгт нийт 5 сүлжээ ашиглаж байна.

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

Засвар механикийн цех, сэлбэг хэрэгслийн агуулах: Засварын цехийн нийт талбай 600м². Жилд ажиллах хоног 300, хоногт ажиллах ээлж 2, ээлжийн ажиллах хугацаа 12 цаг байна. Мөн засварын цехийн хажууд Хөдөлгүүр засварлах өрөөтэй. Өрөөг шаардагдах тоног төхөөрөмжөөр хангасан.

Сэлбэг хэрэгслийн агуулах: Уурхайн ХММ-ын сэлбэг хэрэгсэл, нөөцийн тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, зэргийг хадгалах ба тараахад зориулсан агуулах юм. Сэлбэг хэрэгслийн агуулахын талбай 600м². Жилд ажиллах хоног 300, хоногт ажиллах ээлж 1 ээлжинд 12 цагаар ажиллана.

Шатах тослох материалын агуулах: Тээврийн хэрэгсэл ба засвар үйлчилгээний техник тоног төхөөрөмжүүдийн шатахууныг хадгалах ба тараахад зориулан шатахуун хадгалах сав, шатахуун цэнэглэх түгээгүүр ба нөөц шатахууны агуулах тус бүр байгуулна.

Шатахуун түгээх станц ба нөөцийн шатахууны агуулах: Дизель түлш хадгалах 2 ширхэг сав тус бүр 1000 м³-ийн багтаамжтай, 500 м³-ийн багтаамжтай сав 1 ширхэг, 50м³-ийн 5 ширхэг сав, 25м³ 1 ширхэг сав. Бензин хадгалах 15 м³ 1 ширхэг савуудыг байршуулсан. Жилд 300 хоног, 2 ээлжээр 12 цагаар ажиллана.

Тэсрэх материалын агуулах: Баянголын ил уурхайн тэсрэх бодисын болон тэсэлгээний хэрэгслийн агуулах нь уурхайн тосгоноос хойд зүгт 7 км-т, зүүн ил уурхайгаас баруун зүгт 16 км зайд байрлана. Тэсрэх бодисын 120 тоннын багтаамжтай агуулах, тэсэлгээний хэрэгсэл хадгалах зориулалт бүхий 40тн-ын 3 чингэлэг тус тус байна. Тус уурхайн тэсэлгээний ажлыг гүйцэтгэдэг “Монтай Эрдэнэ” ХХК хариуцан гүйцэтгэдэг.

Төмөр замын тээвэр: Засгийн газрын 2008-04-09-ний өдрийн 134 тоот тогтоолын дагуу “УБТЗ” ХНН-н Ерөө өртөөнөөс Ерөө сумын нутаг дэвсгэрт байрлах Баянголын төмрийн орд газар хүртэл Хандгайт нэртэй газар эцсийн өртөөг 2008-2012 онд барьж байгуулсан. Ингэхдээ Монгол Улсын төмөрзамын MNS 6229-2010 стандартын дагуу 1520 мм буюу өргөн царигтай P50 загварын зам төмөртэй, төмөр бетон дэрэн бүтэцтэй төмөр замыг барьж төмөр замын суурь бүтцийн Дархан, Сэлэнгийн чиглэлд багтсан орон нутгийн салаа замыг буй болгосноор бүс нутгийн ачаа тээврийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь болсон юм. Баянголын төмөр замын гол замын урт – 83.7км Нийт төмөр замын дэлгэмэл урт нь - 115км Төмөр замын тээврийн үйл ажиллагааг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр замын газраас олгосон төмөр замын Тээвэрлэгчийн 03 тоот гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн дагуу явуулж байна. Төмөр замын тээвэрт зориулан ОХУд үйлдвэрлэсэн 12-132 загварын ашиглагдаж байсан 1000 ширхэг, БНХАУ-д үйлдвэрлэсэн ЕС-70 загварын Монгол Улсын төмөр замын 1520 мм буюу өргөн царигтай төмөр замын стандартын шаардлагахангасан 2003 ширхэг ачааны шинэ хагас вагон нийт 3003 ширхэг өөрийн эзэмшлийн вагоныг ачаа тээвэр болон баяжмал тээврийн эргэлтэд оруулан ажиллаж байна.

Гадаад тээвэр: Төмрийн баяжмалыг автомашин болон төмөр замаар тээвэрлэн БНХАУ-д экспортлоно. Баянголын төмрийн хүдрийн ил уурхайгаас Хандгайт өртөө хүртэл маршрутаар нийт 15 км шороон замаар тээвэрлэнэ. Төмөр замын тээвэр: Хандгайт өртөөнөөс улсын урд хил хүртэл тээвэрлэх зай 1160 км төмөр замаар тээвэрлэнэ.

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ҮНЭЛГЭЭ

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших MV-008888, MV-017607 тоот тусгай зөвшөөрлийн дугаартай “Баянголын төмрийн хүдрийн орд”-ыг ил аргаар ашиглах, хуурай баяжуулах үйлдвэрийн төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийг доорхи хүснэгт үзүүлэв. Энэхүү арга нь төслийн үйл ажиллагааны үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал “х”-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэхийг тодруулах) байдлыг үзүүлдэг.

Хүснэгт-3. Төслийн хэрэгжих үеийн байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

№	Байналь орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөл			Хугацаа		Давталт		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүчтэй
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1. Биологийн төрөл зүйлийн оршин амьдрах нөхцөл											
1	Гадаргын урсацын өөрчлөлт	x				x		x		x	
2	Газрын доорхи усны урсацын өөрчлөлт	x			x		x			x	
3	Ургамлын бүтцийн өөрчлөлт		x				x			x	
4	Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x			x
5	Геологийн тогтоцын өөрчлөлт	x				x		x		x	

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

6	Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт		x			x		x	x		
7	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			x	x		x		x		
2. Байгаль орчны аюул осол											
8	Ашиглалт, хадгалалтаас шалтгаалах аюул осол		x		x		x		x		
9	Байгаль орчны аюул нэмэгдэх, магадлал нь ихсэх шалтгаан бий болох		x			x		x	x		
10	Тухайн орон нутгийн байршил нь аюулт үзэгдлийн нөлөөлөлд эмзэг байх		x			x		x	x		
3. Байгалийн нөөц ашиглалт											
11	Газрын гадаргын нөөц баялаг	x				x		x		x	
12	Бэлчээрийн байдал	x				x		x			x
13	Газар тариалан	x				x		x			x
14	Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x			x

**“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч
хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө**

1 5	Эрчим хүчний нөөц		x		x		x		x		
4. Байгаль орчны өөрчлөлт											
1 6	Гадаргын усны чанарын өөрчлөлт	x			x		x			x	
1 7	Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх		x		x		x		x		
1 8	Агаарын бохирдол	x			x		x		x		
1 9	Хөрсний бохирдол	x				x		x			x
2 0	Дуу чимээ, шуугианы нөлөө		x		x		x		x		
5. Нийгэмд үзүүлэх нөлөө											
2 1	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх		x		x		x		x		
2 2	Нүлгэн шилжүүлэх асуудал гарах	x			x			x		x	
2 3	Хүн амын орлого өөрчлөгдөх		x		x		x		x		
6. Байгалийн үзэсгэлэнт нутаг, амралт жуулчид											
2 4	Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	x				x		x			x
2 5	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x			x
7. Түүхийн дурсгалт зүйл, соёлын өв, археологи, палеонтологийн олдвор											

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

26	Түүх соёлын дурсгалт зүйлд										
27	Археологи, палеонтологийн олдворт										
8. Эдийн засаг, байгаль орчин											
28	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	х		х		х				х	
29	Орон нутгийн орлого нэмэгдэх	х		х		х				х	
30	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ	х		х		х		х		х	
31	Ажлын байр нэмэгдэх		х	х				х			
32	Ядуурлыг бууруулахад дэмжлэг		х	х				х			
33	Усжуулах гэх мэт газар ашиглалт нэмэгдэх			х		х					

Тайлбар: х-болзошгүй нөлөөлөл, бөглөгдөөгүй нь уурхай, баяжуулах үйлдвэрлэлд хамаарахгүй.

Бонгино хугацааны нөлөөлөлд: Уурхайн шүүрлийн усны улмаас газрын доорх усны чанар, хэмжээ өөрчлөгдөх, хүнд машин механизмуудаас агаарт бохир утаа хаягдах, тэдгээрийн хөдөлгөөнөөс агаарт тоос шороо дэгдэх болон дуу шуугианы нөлөөгөөр орон нутгийн иргэдийн ая тухтай байдал алдагдах, релефийн өөрчлөлтөөс бичил орчны уур амьсгалд нөлөөлөх зэрэг сөрөг нөлөөтэйгээс гадна орон нутгийн төсөвт оруулах орлого, татварын орлого болон ажлын байр нэмэгдэх эерэг нөлөөтэй байна. Урт хугацааны нөлөөлөл: Уг ордоос хүдэр олборлох уулын ажлын явцад байгаль орчинд удаан хугацаагаар нөлөөлөх 13 нөлөөлөл нь бүгд буцалтгүй нөлөөлөхөөр байна. Үүнд хөрсний элэгдэл, эвдрэл, гадаргын усны горимын өөрчлөлт, эрдэс түүхий эдийн болон бэлчээрийн нөөц, байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх, зэрлэг амьтдын амьдрах орчин хязгаарлагдах

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

зэрэг нөлөөлөл хамаарч байна. Иймээс хүдэр олборлолтын явцад байгаль орчинд үзүүлэх дээрх сөрөг нөлөөллүүдийг хамгийн бага байлгахар техник технологийг сонгон ажиллаж мөн байгалийн унаган төрхийг алдагдуулсны дараа нөхөн сэргээх ажлыг холбогдох стандартын шаардлагад нийцүүлэн хийх шаардлагатай. Энэ талаар сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан.

Нөлөөллийн эрчим: Гадаргын усны урсацын өөрчлөлт, хөрсний элэгдэл эвдрэл, геологийн тогтоцын өөрчлөлт, эрдэс түүхий эдийн нөөцийн болон бэлчээрийн хомсдол, байгалийн үзэсгэлэнт байдлын өөрчлөлт зэрэг нь хүчтэй сөрөг нөлөөлөл болох учир байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тодорхой тусган уурхайн олборлолтын явцад мөрдлөг болгон ажиллахыг төсөр хэрэгжүүлэгчид зөвлөж байна. Үүний зэрэгцээ газрын гадаргын нөөц баялаг болох ургамлын ургац, газрын доорх усны хэмжээ, чанарт, геологийн тогтоцод дунд зэргийн эрчимтэй нөлөөлөхөөр байна. Байгаль орчинд үзүүлэх нийт нөлөөллийн 21.2% нь хүчтэй, 27.27% нь дунд зэргийн, 42.42% нь бага зэргийн эрчимтэй нөлөөлөхөөр байна.

Төслийн байршил, шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл: Баянголын төмрийн хүдрийн орд”-ыг ил аргаар ашиглах, хуурай баяжуулах үйлдвэрлэлийн процесс Засаг захиргааны хувьд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт явагдана. Уг Баянголын төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төслийн байршил, техник-технологийн шийдэл, төлөвлөлт болон төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдсон болзошгүй нөлөөллийг тодруулахын тулд “магадлан жагсаах” (checklists) аргыг хэрэглэн үр дүнг нь дараах хүснэгтээр үзүүлэхээр зорисон болно.

Хүснэгт-4. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлах жагсаалт

№	Байналь орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөл			Хугацаа		Давталт		Эрчим			
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүчтэй	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
1. Биологийн төрөл зүйлийн оршин амьдрах нөхцөл												
1	Гадаргын урсацын өөрчлөлт	x			x							
2	Газрын доорхи усны		x	x								x

**“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч
хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	урсаын өөрчлөлт										
3	Ургамлын бүтцийн өөрчлөлт	x				x			x		
4	Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x	x		
5	Геологийн тогтоцын өөрчлөлт		x		x			x			x
6	Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт	x				x		x			x
7	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт										
2. Байгалийн нөөц ашиглалт											
8	Газрын гадаргын нөөц баялаг					x		x		x	
9	Бэлчээрийн байдал	x				x	x			x	
10	Эрдэс түүхий эдийн нөөц		x			x		x		x	
11	Эрчим хүчний нөөц			x	x						x
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт											
12	Гадаргын усны чанарын өөрчлөлт	x	x		x						x
13	Гадаргын усны чанарын өөрчлөлт						x				

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

1 4	Агаарын бохирдол	x	x		x					x	
1 5	Хөрсний бохирдол	x				x				x	
1 6	Хорт бодис усаар дамжих хүн амьтанд нөлөөлөх	x			x		x				x
1 7	Дуу чимээний, шуугианы нөлөө	x			x		x			x	
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор											
1 8	Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	x				x		x			x
1 9	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x		x	
2 0	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
5. Эдийн засаг, байгаль орчин											
2 1	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх		x		x		x			x	
2 2	Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд эерэг нөлөөлөх	x					x			x	
2 3	Хүн амын орлого нэмэгдэх	x					x			x	

**“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч
хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө**

2 4	Хүн амын тоо өөрчлөгдөх	х					х			х	
2 5	Хувийн өмчийн болон татварын орлого нэмэгдэх	х					х			х	
2 6	Орон нутгийн орлого нэмэгдэх	х					х			х	
2 7	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	х					х			х	
2 8	Ажлын байр нэмэгдэх	х					х			х	
2 9	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	х								х	
6. Бусад нөлөөлөл											
3 0	Үйлдвэрийн барилга байгууламжийн г барих үед орчны хөрсний эвдрэл, бохирдол	х				х				х	х
3 1	Ахуйн болон үйлдвэрийн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс ба газрын доорхи усыг бохирдуулах	х				х				х	

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

3 2	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах сав, үйлдвэрийн хаягдал, барилгын материалын хаягдал зэргээс байгаль орчинд сөргөөр нөлөөлөх	х				х	х				х
Дүн		23	6	2	10	10	13	9	2	17	9

Уг төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарч болох байгаль орчинд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл нь байгалийн нөөц, орчны бохирдолт үүсгэх сөрөг нөлөөтэй, харин улсын болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн асуудалд эерэг нөлөөтэй болох нь дээрхи хүснэгтээс харагдаж байна. Иймд тэдгээрт задлан шинжилгээ хийж дараах дүгнэлт өгч болох юм. Үүнд:

Шууд ба шууд бус нөлөөлөл, түүний эрчим: Болзошгүй нөлөөллийн 23 нь шууд нөлөөлөлд хамаарах бөгөөд үүний 8 нь эерэг нөлөөтэй байна. Энд болзошгүй нөлөөллийн ихэнхи нь (79%) шууд нөлөөлөлд хамаарч буй бөгөөд хөрс шороог хуулах, төмрийн хүдэр олборлох, баяжуулах нь экологийн тухайн системд шууд нөлөөлнө. Нөгөө талаас үйлдвэрийн үйл ажиллагаа эхлэх үед орон нутгийн орлого нэмэгдэх, ажлын байр шинээр бий болох, ядуурлыг бууруулахад дэмжлэг болох шууд эерэг нөлөөлөл нь хүчтэйгээс дунд зэрэг нөлөөтэй байгаа нь хүснэгтээс харагдаж байна.

Үйлдвэрийн болон уурхайчдын тосгон, бусад барилга байгууламжуудыг барих үед хөрсний элэгдэл, эвдрэл гарах, түүнтэй уялдан орчинд тоос, хүнд машин механизмын яндангаас гарах утаа, хий зэрэг нь агаарын орчныг дунд зэрэг бохирдуулах нөхцөлтэй байна. Харин санамсар болгоомжгүйгээс нефтийн бүтээгдэхүүн алдсан тохиолдолд орчны хөрс бохирдуулах магадлал ихтэй тул шууд, дунд зэргийн эрчимтэй нөлөөлөлд хамааруулж үзсэн болно. Богино хугацааны ийм хэлбэрийн нөлөөлөл нь усаар дамжин хүн ам, ан амьтанд нөлөөлөх, үйлдвэрийн барилга байгууламжийг барих үед орчны хөрсний бохирдол гарах, ахуйн болон үйлдвэрийн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс ба газрын доорхи усыг бохирдуулах, хүчтэй салхи, түймэр, газар хөдлөл, аянга зэрэг байгалийн гамшгийн үзэгдлүүдтэй холбоотой сөрөг нөлөөлөл орж байна. Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох эерэг нөлөөлөл мөн энд хамаарч байна.

Нөлөөллийн хугацаа: Энд 10 нөлөөлөл нь урт хугацаагаар, 10 нь богино хугацааны нөлөөлөлд хамаарагдаж байна. (Урт хугацааг 10-аас дээш жилд тооцсон болно) Ордын ойр орчны ургамлын нөмрөгийн талхагдал, бэлчээрийн талхагдал, хөрсний эвдрэл, байгалийн өнгө төрх өөрчлөгдөх, ан амьтны амьдрах орон зайг багасгах зэргийг нөхөн сэргээх арга

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

хэмжээнд урт удаан хугацаа шаардагддаг онцлогтой тул урт хугацааны нөлөөлөлд хамаарагдаж байна.

Буцаж нөлөөлөх: Үүнд ахуйн болон нефтийн бүтээгдэхүүнээр бохирдсон хөрс, гүний усыг бохирдуулах улмаар хүн, мал, амьтаны эрүүл мэндэд шууд ба шууд бусаар эргэж нөлөөлөх, ахуйн хаягдлыг тухай бүр устгаагүй болон ариутгаагүйгээс болж хаягдлын цэгт ялаа шавж үржиж, тэр нь буцаж нөлөөлөх, гал алдсаны улмаас хээрийн түймэр гарч ойр орчмын бусад объект болон ургамалд нөлөөлөх магадлалтай.

Буцалтгүй нөлөөлөл: Энэ төрөлд тухайн сөрөг нөлөөлөл нь байгаль орчинд буцаж нөхөн сэргээх нөхцөл багатай болон сэргээгдэшгүйгээр нөлөөлөх нөлөөлөл хамаарагдана. Газрын нөөц баялаг, геологийн тогтоцын өөрчлөлт, хөрс, газрын элэгдэл эвдрэл, байгалийн үзэсгэлэнт төрх, ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх зэрэг нөлөөллүүд хамаарч байна. Уг ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн үргэлжлэх хугацаа нилээд удаан, эрчмийн хувьд 2(7%) нөлөөлөл хүчтэй, 17 нь (60%) дунд зэрэг байгаа нь нөхөн сэргээх, үүссэн сөрөг нөлөөг багасгах арилгах асуудлыг үйлдвэрийн үйл ажиллагааны үед мөрдөх байгаль хамгаалах болон нөхөн сэргээх төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан ажилтай нарийн уялдуулан хийж байх нь зайлшгүй болохыг дахин баталж байна.

Уурхайг ашиглахтай холбогдож гарах байгаль орчны асуудал: Манай оронд төмрийн хүдрийн ордууд баяжуулалтын технологийн хоцрогдлоос шалтгаалан металл авалтын хэмжээ бага, нөөц ашиглалт төдийлөн хангалтгүй нийтлэг байдлаас үүдэн их хэмжээний нөөц хаягдаж, үүсмэл ордууд бий болдог. Энэ нь уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг саатуулах, гар аргаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг дэлгэрүүлэх нэг нөхцөл болдог. Баянголын төмрийн ордоос төмрийн хүдэр олборлох, баяжуулалтын үед газрын хөрс, түүний дээрх ургамал, газрын хурдасд хүчтэй нөлөөлөх тул байгаль орчны мониторингийг тогтмол хийх, түүнийг нөхөн сэргээх ажлыг байгаль хамгаалах төлөвлөгөө, санхүүжилтэндээ тусган гүйцэтгэх хэрэгтэй.

“Монтай-Эрдэнэ” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн цогцолбор” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг “Магадлан жагсаах” арга болон экспертийн үнэлгээний Матрицын аргыг хослуулан тодорхойлов. Энэхүү үнэлгээний ажлыг 2012 оны 5-р сарын 17-ны өдрийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль /шинэчилсэн найруулгад нийцүүлэн хийсэн болно. БОННУ-ний ажлын явцад төслөөс байгаль орчинд нөлөөлөх гол нөлөөллүүд, хаягдал болон технологийн горимыг нарийвчлан авч үзсэн болно. Эдгээр үзүүлэлтүүдийг газар дээр нь очиж, хэмжилт, судалгаа хийж, дээж авч, авсан дээжиндээ хийсэн шинжилгээний үзүүлэлт дээр тулгуурлан үнэлгээ өгсөн болно. Магадлан жагсаах арга нь нөлөөлөх зүйл байгаа-байхгүй гэсэн зарчим дээр үндэслэж, сөрөг нөлөөллийг “х” ээр, эерэг нөлөөллийг “+”-ээр тэмдэглэдэг. Нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийг илрүүлэхэд зориулагдсан бөгөөд нөлөөлөл нь шууд, шууд бус, буцах ба буцалтгүй, давхардах эсэхийг тодруулах, хугацааны хувьд урт, богино, эрчмийн хувьд хүчтэй эсэхийг үзүүлдэг байна. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах байдлыг 5-р хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 5. Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах байдал

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

№	Байналь орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөл			Хугацаа		Давталт		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Бага зэрэг	Дунд зэрэг	Хүчтэй
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1. Биологийн төрөл зүйлийн оршин амьдрах нөхцөл											
1	Гадаргын урсацын өөрчлөлт										
2	Газрын доорхи усны урсаын өөрчлөлт		-			-		-		-	
3	Ургамлын бүтцийн өөрчлөлт										
4	Хөрсний элэгдэл, эвдрэл	-				-		-		-	
5	Геологийн тогтоцын өөрчлөлт										
6	Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт										
7	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт										
2. Байгалийн нөөц ашиглалт											
8	Газрын гадаргын нөөц баялаг										
9	Бэлчээрийн байдал										

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

10	Эрдэс түүхий эдийн нөөц										
11	Эрчим хүчний нөөц										
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт											
12	Гадаргын усны чанарын өөрчлөлт		-	-		-	-			-	
13	Гадаргын усны чанарын өөрчлөлт		-		-			-		-	
14	Агаарын бохирдол	-		-	-		-		-		
15	Хөрсний бохирдол	-				-		-			-
16	Хорт бодис усаар дамжих хүн амьтанд нөлөөлөх		-			-	-				-
17	Дуу чимээний, шуугианы нөлөө	-		-	-		-		-		
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор											
18	Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх										
19	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх										
20	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
5. Эдийн засаг, байгаль орчин											
21	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+				+		+		+	

**“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч
хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

22	Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд эерэг нөлөөлөх										
23	Хүн амын орлого нэмэгдэх	+				+		+		+	
24	Хүн амын тоо өөрчлөгдөх										
25	Хувийн өмчийн болон татварын орлого нэмэгдэх	+		+		+		+		+	
26	Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+		+			+
27	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		+			+		+	+		
28	Ажлын байр нэмэгдэх	+				+	+			+	
29	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+			+		+		+		
б. Бусад нөлөөлөл											
30	Шороон зам харилцаа, машин механизмын хөдөлгөөн шилжилтээс үүдэх хөрсний эвдрэл	-				-	-			-	
31	Ахуйн болон үйлдвэрийн бохир ус,		-			-	-				-

**“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч
хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө**

	нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс ба газрын доорхи усыг бохирдуулах										
32	Ахуйн хог, хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих		-		-		-		-		
	Сөрөг	6	7	3	6	7	9	3	5	5	3
	Эерэг	5	2	1	1	6	2	5	2	5	0

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

2024 онд БОМТөлөвлөгөөг хэрэгжүүлэх зохион байгуулалт өмнөх жилүүдийнхээс өөрчлөгдөхгүй. Дараах зорилго, зорилтыг авч хэрэгжүүлэхээр тусгав. Үүнд:

- ✓ Байгаль орчны дотоод аудитыг тогтмолжуулах гарах эрсдэл, учирч болох нөлөөллөөс урьдчилан сэргийлэх
- ✓ БОНБНҮнэлгээ болон бусад шаардлагатай бичиг баримтуудад тусгагдсан заалтуудыг хэрэгжүүлэх
- ✓ Байгаль орчны хуулийн хэрэгжилтийг хангах, шаардлагатай дүрэм журмыг боловсруулан мөрдөн хэрэгжүүлэх, хэвшүүлэх
- ✓ Тэрбум мод хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- ✓ Талуудын оролцоог хангах, ОХШХ-нд олон нийтийн оролцоог хамруулах, тайлагнах тогтолцоог сайжруулах
- ✓ Орчны бохирдлоос сэргийлэх зорилгоор хог хаягдлыг ил хаяхгүй байх, тусгай зориулалтын бүхээгтэй машинаар тээвэрлэх, хуваарьт цэвэрлэгээ хийх зэрэг ажиллагааг уурхайн хэмжээнд мөрдөх, шинэчлэн батлагдсан хог хаягдлын журмыг мөрдүүлэх
- ✓ Байгаль орчны суурь судалгааны ажлыг /агаар, хөрс, ургамал, ус/ тогтсон хуваарийн дагуу хийж төсөл төлөвлөгөө боловсруулах, мэдээллийн сан үүсгэх
- ✓ Усны хэрэглээг /унд ахуйн/ багасгах зорилгоор байгаль орчинд ээлтэй шинэ дэвшилтэт тоног төхөөрөмж судалж нэвтрүүлэх, хэрэглээг тогтмол хянах
- ✓ Сум орон нутгийн бодлоготой уялдуулан нөлөөлөлд оршин суугч, малчин иргэдийг нөхөн сэргээлт болон ойжуулалт, судалгаа шинжилгээний ажилд татан оролцуулах, хамтарч ажиллах, сум орон нутагт актаар хүлээлгэн өгөх
- ✓ Тусгай зөвшөөрлийн талбайд малчид иргэдийн хадлан бэлчээр, түлээ модны асуудалд хяналт тавих, хамтарч ажиллах
- ✓ ОХШХ-г байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг шинжлэх ухааны үндэслэлтэй аргачлал, стандартаар хянаж, хяналтын үр дүнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг нарийвчлан тогтоох

**“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч
хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө**

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

БУУРУУЛАХ

Хүснэгт-5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нэгж зардал /мян.төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах							
Уурын зуухнаас CO ₂ хүлэмжийн хий ялгарснаар агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг нэмэгдүүлэх	Яндангийн утаанд агуулагдах бохирдуулагч бодис буюу CO, SO ₂ , NO ₂ , үнсийг хэмжүүлж байх	Дулааны станц	-	2	ОХШХ-ийн зардалд	5, 9 сард	MNS 5919 : 2008
Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар, арчилгаа тогтсон хуваарийн дагуу хийх	Уурхайн дотоод тээврийн замууд	ҮАЗ	Тухай бүрт	ҮАЗ	Жилийн турш	MNS 5885:2008 MNS ISO 4227:2002
	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах – хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэх	Уурхайн талбайн дотоод болон талбайн гадна	ҮАЗ	Тухай бүрт	ҮАЗ	Жилийн турш	MNS 6063:2010

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

	Тээврийн хэрэгслүүдэд байрлуулсан GPS-ийн мэдээнд хяналт тавих (шаардлагатай бол хурдны хязгаарын тэмдэг, тэмдэглээ байрлуулах/	ашиглагдаж буй замууд	ҮАЗ	Тухай бүр	ҮАЗ	Жилийн турш	
Тэсэлгээнээс тоос дэгдэх, дуу шуугиан, доргио чичиргээ үүсэх	Тэсэлгээний үйл ажиллагааг явуулахдаа агаарын доргилт чичиргээний талаарх үндэсний болон олон улсын стандартын дагуу гүйцэтгэх	Ил уурхай болон уурхайн ажилчдын суурин	ҮАЗ	Тухай бүр	Дотоод зохион байгуулалтаар	Жилийн турш	Монгол улсын хууль “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай”
Баяжуулах үйлдвэрийн анхдагч бутлуур, хүдрийн агуулахаас тоосжилт бий болох	Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах, тэдэнд сургалт, сурталчилгаа явуулах	Уурхайн бүх ажилчдад	ҮАЗ	Тухай бүр	Дотоод зохион байгуулалтаар	Жилийн турш	MNS(ISO)1 368 8:2000 MNS 3306:1991 MNS
Хөрсөн бүрхэвч, газаргын хэлбэрт үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах, арилгах							
	Аливаа газар хөндөх үйл ажиллагааны өмнө шимт болон шимэрхэг хөрсний	Уурхайн эдэлбэр газарт	ҮАЗ	Тухай бүрт			MNS 5917:2008,

**“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч
хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө**

Хөрсөн бүрхэвчийг хөндөж хуулж хадгалах	гүнийг талбай тус бүрд тогтоож, тогтоосон хэмжээнд хуулж, хадгалах						MNS 5918:2008
	Газарзүйн мэдээллийн системд шимт, шимэрхэг хөрсний овоолгуудын байршил, хэмжээг бүртгэх, зурагжуулах,	Уурхайн эдэлбэр газарт	ҮАЗ		Тухай бүрт		MNS 5916:2008
	Үйл ажиллагааны багуудад газар хөндөх зөвшөөрөл, ховор ургамал хамгаалал, нөхөн сэргээлттэй холбоотой сургалт хийх		1 000.0	1	1 000.0	-	MNS 5924:2015
	Дотооддоо мөрддөг асгаралтын журмын дагуу засвар үйлчилгээний талбайнуудад ШТМ-ын асгаралтаас урьдчилан сэргийлэх зорилгоор тосох сав поошигнуудыг боловсронгуй болгох, асгаралт үүссэн тохиолдолд саармагжуулах арга хэмжээ авах, хэрэглэгдэх материалуудыг (үртэс, хужир г.м) байршуулах.	Засварын талбайд	ҮАЗ	-	ҮАЗ	Тухай бүрт	MNS 5850:2008

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

Гадаргын болон газрын доор усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах							
Ундны усны чанар алдагдах	Усыг үр ашигтай хэрэглэх талаар ухуулга, сурталчилгааг ажилчдад хийх, мэдээллийн хуудсыг зарын самбарт байрлуулж шинэчилж байх	Ажилчдын амьдрах байр, хотхон	Дотоод зохион байгуулалтаар	1	-	Тухай бүрт	Усны тухай хууль,
Үйл ажиллагаанаас үүдэн усны нөөц хомсдох, нөөцөд хохирол учрах	Үйл ажиллагааны улмаас үүсэх нөлөөллийг тодорхойлох зорилгоор усны мониторингийн цооног өрөмдөж судалгааны цэгийг нэмэгдүүлэх	Уурхайн эдэлбэр газарт	ҮАЗ	-	-	Төлөвлөгөөт онд	
	Ил уурхайд шүүрч буй усыг тогтмол шавхаж зам талбайн тоосжилтыг багасгах зорилгоор эргүүлэн ашиглах	Уурхайн дотоод тээврийн замууд	Ус ашиглалтын зардалд орох	-	-	Төлөвлөгөөт онд	
Газрын доорх усыг ашигласнаар усны нөөц хомсдох, нөөцөд хохирол учирч болзошгүй	Усны түвшин бууралтыг зохих хэмжээнд ашиглах, гүний хоолойн уст давхаргын усны түвшинд цооногийн хэмжилтийг тогтмол хийх	Баянгол, Хандгайт гол, Хяналтын цооногууд	ҮАЗ	-	-	Төлөвлөгөөт онд	

**“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч
хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	Усны тухай хууль тогтоомжийн дагуу ус авах цэг, газар доорх усны цооног бүрт тавигдсан тоолуурын баталгаажилт хийх	Ашиглалтын худгуудын	-	-	-	Төлөвлөгөөт онд	
Уурхайн үйл ажиллагаагаар гадрагын усны бохирдол үүсэх	Гадрогын усан орчны цэвэрлэгээг хийх,	Орон нутагт	ҮАЗ	-	-		
Ургамлан нөмрөг, ойн сан, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах							
Ховор ургамлууд нөлөөлөлд өртөж доройтох, дарагдах, устах	Ургамлан бүрхэвч, ховор ургамлын суурь судалгааг хийх, мэдээлэл цуглуулах, дүгнэлт –зөвлөмжид үндэслэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах	Эвдрэлд орсон талбайд	10, 000.0	1	10, 000.0	Тухай бүрт	Мэргэжлийн байгуулгаар
	Бүртгэгдсэн ховор ургамлын тархалтын мэдээллийг мэдээллийн санд бүртгэлжүүлэн, зураглал гаргаж байх	Уурхайн эдэлбэр газарт	ҮАЗ	1	-	Төлөвлөгөөт онд	-
Амьтны аймагт нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний чиглэлээр							

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

Уурхайн олборлолт, барилга байгууламж өргөжин тэлэх явцад амьтын амьдрах орчин хомсдох, шууд хуваагдалд орох	Ган зуд болон байгалийн цаг уурын хүнд нөхцөл үүссэн тохиолдолд Зэрлэг Амьтан, шувуудыг хамгаалж шаардлагатай газруудад үерийн ус хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах		ҮАЗ	1	ҮАЗ	Төлөвлөгөөт онд	-
Амьтад тээврийн хэрэгсэлд дайруулах, цахилгаанд цохиулах зэрэг шууд үхэл хорогдолд орох	Уурхайн үйл ажиллагааны талбай, дэд бүтцийн шугам дагуух эндсэн амьтны судалгааг хийх, бүртгэх, сэг зэмийг зайлуулах, булж устгах	Уурхайн эдэлбэр газарт	ҮАЗ	-	-	Тухай бүрт	
Амьтад, тэдгээрийн нүүдэл, шилжилт хөдөлгөөн, мөн төслийн талбайн дотор болон гадна анхаарал болгоомжтой зорчих талаар жолооч нарт сургалт явуулах		Ууурхайн нийт жолооч нарт	ҮАЗ	-	ҮАЗ	Төлөвлөгөөт онд	-
Нийт					11,000.0		

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны мэргэжилтнүүд уурхайн олборлолтын багуудтай нягт хамтран ажиллаж, байгаль орчны гүйцэтгэлийг оновчтой болгох, уурхайн олборлолтын хугацааны турш орон нутгийн иргэдийн амьдрах орчныг хэвийн байлгахад чиглэсэн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг үе шаттайгаар авч хэрэгжүүлж байна.

Иймд “Болд төмөр Ерөө гол” ХХК нь ТЭЗҮ-д тусгаснаар уурхайн ашиглалтын явцад үүссэн овоолгын нөхөн сэргээлтийн ажлыг 2020 оноос хийж эхлүүлээд байна. 2023 онд баруун уурхайн хөрсний 2-р овоолгод техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 2,6 га талбайд хийж гүйцэтгэн орон нутагт актаар хүлээлгэн өгч ажилласан. Тайлант онд тус овоолгод биологийн нөхөн сэргээлтийн ажлыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөв.

Төлөвлөгөөт онд баруун уурхайн хөрсний 3-р овоолгын **2.4 га** талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж ажиллахаар төлөвлөж байна.

Хүснэгт-6.1. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Техникийн нөхөн сэргээлт	Баруун уурхайн хаягдлын 3 дугаар овоолгын талбайд нөхөн сэргээлтийн стандартыг баримтлан ажиллах	Уурхайн хөрсний овоолгод	га	2.4	-	20,000.0	2024 оны турш	MNS 5917:2008
Биологийн нөхөн сэргээлт	Баруун уулын хөрсний 2-р овоолгод нөхөн сэргээлтийн ажлыг хийх	Уурхайн үндсэн нөхөн сэргээлт	га	2.6	-	10,000.0	2024 оны 5-6 сард	MNS 5918:2008

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

	Өөрийн МҮГ-т бойжуулсан 2-3 настай жимсний мод бутыг баруун уурхайн 2019 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн 3,7 га талбайг ашигт ургамлын төгөл болгон МУ-д баримталж буй стандартыг баримтлан тариалах	Уурхайн үндсэн нөхөн сэргээлт	га	3,7	-	5,000.0	2024 оны турш	MNS 5918:2008
	Нийт					35,000.0		

ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

АРГА

Уурхайн үйл ажиллагааны бүхий л үе шатуудад хийгдсэн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнүүд болон нэмэлт тодотголуудад тусгагдсан сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээнүүдээс гадна байгаль орчныг хамгаалах дүйцүүлэн хамгааллын ажлыг стандарт, шаардлагыг тогтмол мөрдөн үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.

Үйл ажиллагааны нөлөөгөөр устсан байгалийн нарс, хусан ойг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаж ажиллахаар зорилт тавьлаа.

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

Хүснэгт-7.1. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Талбайн хэмжээ /га/	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Уурхайн хэмжээний үлдэгдэл нөлөөллийг багасгах	Эвдэрч олон жил эзэнгүй орхигдсон газарт дүйцүүлэн хамгаалаха ажлыг төлөвлөх	Орон нутгаас заасан талбай буй эвдэрч олон жил эзэнгүй орхигдсон газарт техникийн нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөж, хийх	5	2000.0	10000.0	Хавар, намар	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал А/138 тушаал
Нийт					10 000.0		

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагааг 18 дахь жилдээ явагдаж байгаа бөгөөд үйлдвэрлэлийн болон уурхайн бүсийн ойролцоо нүүлгэн шилжүүлэх газар, айл байхгүй тул 2024 оны БОМТөлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдахгүй.

ЕС. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт орших Баянгол уурхайн 8888А тусгай зөвшөөрөл бүхий талбайд Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар бүлгийн 27 дугаар зүйлийн 8-т заасны дагууд археологийн судалгааны ажлыг хийлгэхэд хайгуулын ажлын хүрээнд нийт 8 дурсгал илрүүлсэн бөгөөд дээрх дурсгалууд нь Монгол орны нутаг дэвсгэр дээр амьдарч байсан эртний нүүдэлчдийн түүхэнд холбогдох археологийн дурсгалууд болохыг тогтоосон.

Археологийн судалгаагаар илэрсэн дээрх 8 дурсгал нь уурхайн хотхон дотор байрласан байсан бөгөөд тус уурхайн хотхон шилжих тул энэхүү уурхайн хэрэгсүүрт авран хамгаалах малтлагыг 2022 онд ШУА-ын археологийн хүрээлэнгээр археологи, палеонтологийн судалгааг хийлгүүлж, дүгнэлт гаргуулж ажилласан. Тус дүгнэлтээр НТ-ын VI-IX зууны үед хамаарах тахил тайлга үйлдэж байсан шүтлэг бишрэлийн газар болох нь тогтоогдсон тул авран хамгаалах ажил хийгдэх шаардлагагүй гэсэн дүгнэлт гарсан. Иймд төлөвлөгөөт онд түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ тусгагдаагүй.

**“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч
хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

АРАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

10.1 Уурхайн тэсэлгээ

Тус уурхайн тэсэлгээний ажлыг 2014 оноос хойш “Монтай-Эрдэнэ” ХХК нь “Эмульсийн тэсрэх материалын үйлдвэр”-ийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж ирсэн. Баянголын ил уурхайн тэсрэх бодисын болон тэсэлгээний хэрэгслийн агуулах нь уурхайн тосгоноос хойд зүгт 7 км-т, зүүн ил уурхайгаас баруун зүгт 16 км зайд байрлана. Тэсрэх бодисын 120 тоннын багтаамжтай агуулах, тэсэлгээний хэрэгсэл хадгалах зориулалт бүхий 40тн-ын 3 чингэлэг тус тус байна. Тэсрэх материалын үйлдвэрт 17 нэр төрлийн химийн бодис ашиглана.

Хүснэгт-10.1. Химийн бодисын нэг жилийн хэрэглээ.

№	Монгол нэр	Олон улсын нэр	Химийн томьёо	(CAS#)	Хэмжээ /тн/
1	Аммонийн нитрат	Ammonium nitrate	NH ₄ NO ₃	6884-52-2	30000
2	Аммонийн нитрат /сүвэрхэг/	Ammonium nitrate porous	NH ₄ NO ₃	6884-52-2	25000
3	Натрийн нитрат	Sodium nitrate	NaNO ₃	7631-99-4	700
4	Натрийн нитрит	Sodium nitrite	NaNO ₂	7632-00-0	6.5
5	Фосфорын хүчил	Phosphoric acid	H ₃ PO ₄	7664-38-2	4.1
6	Цуу хүчлийн натри	Sodium acetate	CH ₃ COONa	127-09-3	1.5
7	Цууны хүчил	Acetic acid	CH ₃ COOH	64-19-7	3.0
8	Натрийн додецил сульфат	Sodium dodecyl sulphate	CH ₃ (CN ₂) ₁₁ OSO ₃ Na	151-21-3	0.6
9	Эмульсжүүлэгч PIBSA NB2424	Emulsifier PIBSA, Polysibutylene succinic anhydride8 NB2424	-	-	135
10	Эмульсжүүлэгч SMO, S-80	Emulsion /Emulsifier/ SMO S-80	-	1338-43-8	210
11	Минерал	Mineral oi acidl	C ₁₈ -C ₃₄	8042-47-5	210
12	Цайрын нитрат	Zinc nitrate	Zn(NO ₃) ₂	10196-18-6	5.5
13	Нимбэгний хүчил	Citric acid	C ₆ H ₈ O ₇	77-92-9	3
14	Хөнгөнцагаан	Aluminum	AL	7429-90-5	150
15	Тринитрофенил-метилнитрамин	Trinitrophenyl-methylnitramine /tetryl, tetrytol/	C ₇ H ₅ N ₅ O ₈	479-45-8	360
16	Натрийн перхлорат	Sodium perchlorate	NaCLO ₄	7601-89-0	700
17	Шоргоолжны хүчил	Formic acid	HCOOH	64-18-6	3

**“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч
хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө**

Материалын агуулах нь “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний эргэлтэнд хяналт тавих тухай” хуулийн 14.4-т заасны дагуу тогтоосон байршилд үндсэн болон туслах үйлдвэрийн зориулалт бүхий барилга байгууламжийн иж бүрэн цогцолбор байна. Тэсрэх материалын агуулах ба тэсрэх материал хадгалах зориулалт бүхий байрыг “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” болон стандартын шаардлагад бүрэн нийцсэн, батлагдсан тоног төхөөрөмжийн дагуу бүрэн тоноглогдсон байна. Тэсрэх материалын агуулахын хамгаалалтыг “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн 7-р хавсралтаар батлагдсан “Тэсрэх материалын агуулахын хамгаалалтын нэгдсэн журам”-ын дагуу ажиллуулна.

10.2 Баяжмалын агуулга тодорхойлох лаборатори, ашиглаж буй химийн бодис

Химийн лабораторийн танилцуулга Баянголын уурхайн мимийн лаборатори нь химийн инженер-2, химийн мэргэжилтэн-3, дээж бэлтгэгч-3 гэсэн 8 орон тооны ажилтантай.

Химийн инженер-2: Химийн лабораторийн ерөнхий үйл ажиллагааг хариуцан ажиллана. Лабораторийн ажилчидын ажил үүргийн хуваарилалт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, химийн шинжилгээ, химийн туршилт судалгааны ажлыг хийнэ. Мөн төмрийн хүдрийн сорьцлолт, дээж бэлтгэл, шинжилгээний бодис урвалж, уусмалыг бэлтгэх, химийн шинжилгээ хийх, багажит анализ, төмрийн хүдрийн баяжуулалт, боловсруулалтын технологийн туршилт судалгаа шинжилгээг хийх болон судлаач инженерийн үүргийг хавсран гүйцэтгэнэ.

Химийн мэргэжилтэн-3: Төмрийн хүдрийн дээж бэлтгэл, шинжилгээний бодис урвалж, уусмалыг бэлтгэх, химийн шинжилгээ хийх, багажит анализ, лабораторийн дотоод багаж тоног төхөөрөмжийг хариуцан ажиллана.

Дээж бэлтгэгч - /тоо-3/: Төмрийн хүдрийн баяжуулалтын технологийн шат дамжлагаас анхдагч хүдэр, баяжмал болон хаягдалын дээж авах болон геологи хайгуул, судалгаа шинжилгээний дээжүүдийг буталж, нунтаглаж химийн шинжилгээнд хүлээлгэн өгөх үүргийг гүйцэтгэнэ.

Химийн лабораторийн барилга байгууламж, дотоод зохион байгуулалт: Химийн лабораторийн барилга байгууламж нь зоорийн давхаргүй, 2 давхар, аянга зайлуулах төхөөрөмж суурилуулсан, 380 вольт хүчдэлд холбогдсон, дулааны болон цэвэр, бохир усны систем, шингэн хаягдал зайлуулах шугамд холбогдсон, 1 хүнд ноогдох талбайн хэмжээ нь стандарт нөхцлийг бүрэн хангасан. Мөн шаардлагатай туршилт, шинжилгээг явуулах нөхцөл боломж, багаж тоног төхөөрөмжөөр бүрэн тоногдсон. Химийн лабораторийн барилгын 1-р давхарт дээж бэлтгэх болон хувцас угаалгын газар, 2-р давхарт химийн шинжилгээний лаборатори, албан тасалгаа байрлана.

Багаж тоног төхөөрөмжийн хувьд: хацарт бутлуур, булт бутлуур, аягат тээрэм, хатаах шүүгээ, янз

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

бүрийн хэмжээт шигшүүрүүд болон бусад туслах хэрэгслүүд зэрэг дээж бэлтгэлийн болон химийн шинжилгээний шил сав, аналитик жин, татах шүүгээ, ус нэрэх аппарат, шатаах зуух, усан банн, цахилгаан плитка, хатаах шүүгээ, спектрофотометр, микроскоп зэрэг багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан. Нийт 97 нэр төрлийн химийн бодис ашиглана.

Хүснэгт-10.1. Эрсдлийн менежментийн төлөвлөгөө.


Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Цаг агаарын урьдчилсан мэдээлэлд тулгуурлан үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зохион байгуулах	Үйл ажиллагааны хугацаанд	ҮАЗ	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	Компанийн онцгой байдлын үед ажиллах төлөвлөгөө
	Ойн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга, санамж хуудсыг хийж, шаардлагатай газруудад байрлуулах, бэлэн байдлыг хангах, түймэртэй тэмцэх техник хэрэгслийг бэлтгэх					
	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байршуулж ажиллах	Ажилчдын амьдрах байр, хотхон	2500.0	2500.0		
Химийн бодисын хүний эрүүл мэнд ба хүрээлэн буй орчинд үзүүлэх эрсдэл, сөрөг нөлөөлөл	Химийн бодисыг стандартын шаардлага хангасан агуулахад хадгалах, агуулахын бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах	Химийн бодисын лаборатори ажилчид	-	Дотоод зохион байгуулалтаар	Үйл ажиллагааны турш	Химийн хортой ба аюултай бодисын тухай хууль, холбогдох журам, стандарт, ХАБЭА-н тухай хууль
	Химийн бодисын бүртгэл тооллогыг хийж ашиглалтанд хяналт тавьж ажиллах, химийн бодисын үлдэгдэл, хаягдлыг устгах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх		-	Дотоод зохион байгуулалтаар		

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежементийн төлөвлөгөө

Тэсрэх материалын үйлдвэр, агуулах, химийн бодисын эрдслээс урьдчилан сэргийлэх, нөлөөлөөллийг бууруулах арга хэмжээ	Технологийн доголдлын үед гарах ослоос урьдчилан сэргийлж, ослын үед авах арга хэмжээнүүдийг нөлөөллийн хэлбэр бүрээр төлөвлөн устгах	Тэсрэх материалын үйлдвэр, агуулах	ҮАЗ	ҮАЗ	Тухай бүрт	Холбогдох хууль тогтоомж
	Химийн бодисын хадгалалт, ашиглалт, тээвэрлэлтийг химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, Химийн хорт болон аюулиай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах устгах журмыг мөрдөж ажиллах					
Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	Нийт ажилчид	ҮАЗ	ҮАЗ	Өдөр бүр	ХАБЭХТ хууль
	Жил бүр мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдийн тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах				Жилд 1 удаа	
	Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн санг машины забин, ажлын байрт байрлуулах	Үйл ажиллагаанд ашиглаж буй машин механизм				
Нийт				2500.0		

АРВАН НЭГ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт-11.1. Төслийн хэмжээнд хог хаягдлын ангилан ялгалтыг харуулсан схем.



Монгол улсын хог хаягдлын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм журам стандартуудыг хангуулж, үйлдвэрийн газрын хэмжээнд сахин мөрдүүлнэ.

Манай төслөөс дараах хог хаягдлууд гардаг бөгөөд түр цуглуулах цэг болон ангилан ялгах хэсгүүдэд цуглуулдаг.

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт-11.2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгж зардал /төг/	Тоо хэмжээ	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн	Ажилчдын гал тогооноос гарах ногооны хальс, хаягдлаар органик бордоо хийж, цаашид нөхөн сэргээлт болон мод үржүүлгийн талбайд ашиглах, турших ажлыг зохион байгуулах	Төслийн хэмжээнд	ҮАЗ	-	ҮАЗ	Төлөвлөгөөт онд	Хог хаягдлын тухай хууль тогтоомж дүрэм журам, БОНБУ-ний дагуу
	Төслийн хэмжээнд бүх нийтийн их цэвэрлэгээг батлагдсан хуваарийн дагуу тогтмол чанартай хийх ажлыг зохион байгуулж хяналт тавьж ажиллах	Төслийн хэмжээнд	ҮАЗ	14 хоногт 1 удаа	ҮАЗ		
Үйлдвэрлэ-лийн	Дахин ашиглах, боловсруулах боломжтой хог хаягдлын хоёрдогч түүхийг эд боловсруулах үйлдвэрүүдтэй гэрээлэн нийлүүлэх	Төслийн хэмжээнд дахин ашиглах ангилан ялгасан хог хаягдал	-	-	ҮАЗ	Төслийн хугацаанд	
	Хог хаягдалын сургалт зохион байгуулах	Эх үүсвэр дээр	-	-	-	-	
	Лаборатори болон тэсрэх материалын үйлдвэрт ашиглах химийн бодисын сав баглаа боодлын хаягдлыг зайлуулах гэрээ байгуулж ажиллах	Төслийн хэмжээнд	-	-	-	Төлөвлөгөөт онд	

**“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч
хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	Аюултай хог хаягдлын тээвэрлэлт, устгалын холбогдох хуулийн дагуу мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	Ажиллах нийт хугацаанд	2.500.0	2	5000.0	Төлөвлөгөөт онд	Зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах
	Хаягдал тос, хэрэглэгдсэн аккумуляторыг тусгай сав, агуулахад цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх	Төвлөрсөн хогийн цэг дээр					
Нийт					5000.0		

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Жил бүрийн хяналт шинжилгээний үзүүлэлтүүдийг анхааралтай судалж цаашид байгаль орчны менежментийн төлөвлөгөөг улам бүр боловсронгуй болгох, байгаль орчин болон тухайн нутагт амьдардаг иргэдийг сөрөг нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг илүү үндэслэлтэй болгох юм.

Хяналт шинжилгээний үр дүнг нэгтгэн жил бүр холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон аймаг сумын холбогдох албадад хүргүүлж ажилладаг.

Хүснэгт-12.1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Цэгийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар орчны шинжилгээ	Тоосжилт /pm-2.5, pm-10/	5, 9 сар	5	60.0	600.0	Баяжуулах үйлдвэр, технологийн зам, уурхайн бүс БУЦБ, Уурхайн хотхон, Тэсрэх материалын үйлдвэр	MNS 4585:2016
	Агаар дахь бодисын найрлага тодорхойлох /NO ₂ , SO ₂ /	5,9 сар	4	50.0	400.0	Баяжуулах үйлдвэр, технологийн зам, Уурхайн хотхон, Тэсрэх материалын үйлдвэр	
					1000.0		
Хөрсний хяналт шинжилгээ	Нефтийн бүтээгдэхүүн тодорхойлох, хүнд металл	7 сар	4	50.0	200.0	Засварын талбай, ШТС агуулах, клонк, тэсрэх материалын үйлдвэр	MNS 5850:2008 Хөрсөнд агуулагдах оргониз биш бохирдуулагч
	Хөрснөөс эрүүл ахуйн бактерлогийн шинжилгээ хийлгэх	5 сар	2	80.0	160.0	Хог хаягдлын цэг, БУЦБ-ийн орчим	
	Тусгай зөвшөөрлийн	9 сар	1	50.0	50.0	Уурхайн эдэлбэрт	

**“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч
хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	талбайн хөрсөнд агрохимийн шинжилгээ хийлгэх						бодисын хүлцэх хэмжээ MNS 6341:2012
	Шимт хөрсний овоолгуудад чанарын хяналт шинжилгээ хийх	9 сар	5	60.0	300.0	Шимт хөрсний 5-н овоолго	Нянгийн Ерөнхий тоо, Гэдэсний савханцрын таньц, Перфрингенсийн таньц, Салмонелла MNS 3297:91
	Хоосон чулуулгийн овоолгоос хүчил үүсгэх бодисын шинжилгээ хийлгэх	7 сар	2	1000.0	2000.0	Баруун, Зүүн уулын хөрсний овоолгоос	Перфрингенсийн таньц, Салмонелла MNS 3297:91
					2710.0		
Ус орчны хяналт шинжилгээ	Ундны усанд ашиглагдаж байгаа гүний худгаас химийн шинжилгээ	5 сар	4	50.0	200.0	Баянгол, хандгайт гол, Гүний цооног, Тэсрэх үйлдвэр, уурхайн шүүрлийн ус	MNS 900:2005 MNS 4586:98 MNS ISO 6222:1998 MNS ISO 9308-1:1998
	Голын ус, шүүрлийн усны хяналт шинжилгээ	2 удаа	4	50.0	800.0		
	Худгийн уснаас бактерлогийн шинжилгээг мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторт өгч шинжлүүлэх	1 удаа	4	50.0	200.0		
	БУЦБ-д орж буй болон цэвэрлэгдээд гарч буй бохир	2 улирал	2	85.0	340.0	Саарал ус	MNS 4943:2015

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

	усанд хяналт шинжилгээ					
					1540.0	
Нийт		5,250.0				

АРВАН ГУРАВ.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Болд төмөр Ерөө гол” ХХК-ийн удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль тогтоомжийн дагуу уурхайн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ. Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын чиглэлээр дараах ажлуудыг төлөвлөлөө.

Хүснэгт-13.1. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Тайлбар
“Тэр бум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжиж орон нутгийн ойн мэргэжлийн байгууллагуудын төсөл хөтөлбөрийг дэмжиж хамтран ажиллах	Тэрбум мод хөтөлбөр	Дотоод зохион байгуулалтаар	5,9 сар	Төр захиргааны байгууллагын саналын дагуу
“Байгаль орчны тэмдэглэлт ногоон” өдөрлөгүүдийг зохион байгуулж, иргэд, ажилтнуудын байгаль экологийн талаарх боловсрол, мэдлэг, ухамсарыг нэмэгдүүлэх ажлыг төрийн байгууллагатай хамтран хийх	Уурхайн нийт ажилчид	1000.0	Төлөвлөгөөт онд	Мэргэжлийн байгуулгаар
Гэрээт компаниудын үйл ажиллагаанд дотоод хяналтыг тогтмол хийж, илэрсэн зөрчлийг тухай бүрт таслан зогсоож арилгуулах ажлыг авч хэрэгжүүлэх	Төслийн хэмжээнд	Дотоод зохион байгуулалтаар		Байгууллагийн дотоод хяналтын журамын дагуу
Уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас үүсэх шүүрлийн ус болон газар доорх усны		10,000.0		

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

нөлөөллийг тодорхойлох зорилгоор усны мониторингийн цооног нэмэлтээр өрөмдөж гидрогеологийн судалгааг хийлгэх				
Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх	Төслийн хэмжээнд	ҮАЗ		Байгаль орчны аудит хийх эрх бүхий аж ахуйн нэгжээр
Нийт		11,000.0		

АРВАН ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт-14.1. Оршин суугчдад тайлагнах.

БОМТ, Төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
Орон нутгийн иргэд, төрийн захиргааны байгууллага	Тараах материал ашиглах	“Нээлттэй өдөрлөг”-т оролцож, 2024онд Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, төсөл	2023.8	ҮАЗ	Уурхайн удирдлага, Байгаль орчны алба	Сэлэнгэ аймаг Ерөө сум

**“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч
хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

		хөтөлбөрүүдийн танилцуулга хийх				
БОМТ-ний журмын хэрэгжилтийг хүлээн авах ажлын хэсэг	Лекц, тайлан	Байгаль орчны менежментийн тайланг орон нутгийн иргэдийн төлөөлөл болох Гурван Талт Зөвлөлд танилцуулах	2023.11	Дотоод зохион байгуулалт	Уурхайн дарга, Байгаль орчны дарга	Баянгол уурхай
				-		

“Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн Баянгол уурхайн 2024 онд авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөө

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЗАРДЛЫН ЗАДАРГАА /2024 ОН/

Д.Д	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Зардал мян/төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Төслийн талбай	21	11,000.0
2	Нөхөн сэргээлт		3	35,000,0
3	Дүйцүүлэн хамгаалал		1	10,000.0
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох		-	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах		-	-
6	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө		10	2,500.0
7	Хог хаягдлын менежмент		7	5,000.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр		11	5,250.0
9	Удирдлага зохион байгуулалт		6	11,000.0
10	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах		2	-
	Нийт			79,750.0

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжиж ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих төслийн хүрээнд манай байгууллага 100 сая мод тарих чиглэл авсан ба үүнээс Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт 10 сая мод тарих төсөл, 90 сая модыг Ерөнхийлөгчийн тамгын газраас өгсөн чиглэл хөтөлбөрийн дагуу заагдсан газарт мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Мод тарих төслийн бэлтгэл ажлын хүрээнд хүний нөөц, ажиллах боловсон хүчин бэлтгэх, мод үржүүлгийн талбайн өргөтгөл, үр нөөцийг тарилтад бэлтгэх ажлыг тус тус эхлүүлээд байна.

Дээрх хөдөлгөөнийг дэмжиж оролцохдоо Ерөө суманд тогтвортой үйл ажиллагаа эрхэлж байгаа 8-10 орчим мод үржүүлгийн газрын судалгааг хийгээд байна.

Эдгээр аж ахуйн нэгжийн мэргэжилтнүүдийн ажлын арга туршлага, чадавхи, нөөц бололцоо, арга технологи дээр үндэслэж энэхүү хөдөлгөөнийг чанартай, шинжлэх ухааны үндэслэлтэй нүдэнд ил харагдах бодитой үр дүнтэй болгож дэлхий нийтийн өмнө тулгараад буй уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэхэд үнэтэй хувь нэмэр болно гэж үзэж байна.

2024 онд 1.1 сая модыг тарьц болон суулгацаар тарихаар төлөвлөөд байгаагийн 40 хувийг дотоодын нөөц бололцоог ашиглан, үлдсэн 60 хувийг орон нутгийн мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллахаар төлөвлөөд байна.

Нийт тарих талбай, мод:

Гүйцэтгэгч		Га	Мян.ш
1	БОА	140	350
2	Ажилчид	26	65
3	Төслөөр	12	30
4	Гэрээгээр	262	655
Нийт		440	1,100